

үзэгдлийг бодитойгоор авч үзэж, судалж чадахаа больж, дэлхийн түвшингээс хол хоцроход хүрлээ. Үүнээс болж, капиталист орнуудад нийгмийн ухаанаар, тэр ч байтугай, байгалийн ухаанаар социалист орнуудыхаас илүү бүтээл гарч болно, гарсаар ч байгаа гэдэг энэ үнэ нийг үгүйсгэсээр өөрсдөө хоцорлоо.

Ийм үнэнийг одоо хүлээн зөвшөөрөх цаг боллоо.

Бид өнгөрсөн түүхээ сайн ойлгож байж гэмээж нь өнөөдөр хөлөө олж чадна, өнөөдөрөө сайн ойлгож байж гэмээж нь маргаашаа сайн төсөөлж чадна.

**Ш. САНДАГ**

(үргэлжлэлийг дараагийн дугаарт)

### **БНХАУ-ЫН ХҮН АМЫН АСУУДАЛ**

«Проблемы народонаселения» М., «Прогресс» 1989. 312 с.

Эл эмхэтгэлд Хятадын хүн амын өсөлт, төвлөрөл, гэрлэлт, өрх бүлийн байдал болоод нийгэм-эдийн засгийн хөгжлийн хоорондын нөлөө, шүтэлцээ, төрөлтийн хязгаарлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам зэрэг сэдвээр хятад, америкийн нэрт хүн ам зүйч эрдэмтдийн бичсэн шинжилгээний өгүүллүүдийг зөвлөлтийн эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн Баженова Е. С., Судоплатов А. П нар хэсэг орчуулагч лугаа хүч хавсран эх хэл бүрээс нь орос хэлнээ орчуулан нийтэлжээ.

Тус эмхэтгэлд хятадын өөрий нь болон өрнөдийн хүн ам зүйн томоохон эрдэмтэн судлаач тухайлбал хятадын хүн ам зүйн төвийн эрдэмтэн Лю Жэн, Тянь Сюеюань, Гу Зяньтань нар болон америкийн хүн ам судлалын нэртэй мэргэжилтэн Дж. Бонгаартс, С. Гринхалф зэргийн бүтээлийг оруулжээ. Энэ ном өнөөгийн хятадын хүн амын асуудлын гол ээдрээ түүнийг тайлах арга замын тухай уншигчдад таниулан ойлгуулах зорилго агуулжээ.

Хятад улс хүн амын тоогоороо дэлхийд нэгдүгээрт орох бөгөөд 1987 оны сүүлч гэхэд 1,080 тэрбум хүнтэй болжээ. 1949 онд БНХАУ байгуулагдсаны дараа 540 сая хүнтэй байж, түүнээс хойшхи 38 жилийн дотор Хятадын хүн даруй 2 дахин нэмэгдсэнээр эдүгээ дэлхийн хүн амын 22 хувийг эзэлж байна. Хүн амын суурьшил нягтрал маш тэнцвэргүй 1/10 нутаг дэвсгэрт хүн амын 80 % амьдарч байхад, дорнод мужуудад хүн амын нягтрал 1 хав. дөр.км-т 590 хүн ногдож байна. Дэлхий даяар, хүн амын тоог тооллогын дүнгээр гаргадаг дэлгэрсэн арга бий. БНХАУ байгуулагдсан цагаас хойш 3 удаа тооллого болов. Үүнд: 1953 онд 601,9 сая, 1964 онд 723,1 сая, 1982 онд 1008,2 сая хүнтэй байлаа.

Эмхэтгэлийг хятадын томоохон хүн ам зүйч Лю Жэний «БНХАУ ын хүн ам» өгүүллээр эхэлж байна. (26—63 дахь тал). Түүний бүтээлд хүн ам зүйн байдлын үндсэн шинжүүдийг нарийн тодорхой гаргажээ. Үүнд сүүлийн арван жил дэх хүн амын өсөлтийн ерөнхий байдлыг шинжлэн тодорхойлсны зэрэгцээ улс орны нийгэм эдийн засгийн хөг-

жилд учруулсан үр дагаврыг задлан шинжилсэн байна. «Хятадын хувьд, улс ардын аж ахуй дахь тэнцвэргүй байдлыг арилгах, хүн амын төрөлт болон үйлдвэрлэлийн материаллаг баялагийн хооронд зүй зохистой харьцаа тогтоох нь амин чухал асуудал юм. Энэ бол нийгмийн үйлдвэрлэх хүчний түргэн хөгжил, хүн амын амьдралын түвшинг үндсээр нь дээшлүүлэхэд зайлшгүй хэрэгтэй гэжээ. (54 дэх тал) Хятадын хүн амыг 1,2 тэрбумаас хэтрүүлэхгүйн тулд өрх тутамд нижгээд хүүхэдтэй байхад хүрвэл хятадын хүн ам нийтдээ хөгшрөх тийшээ хандаж, нийгмийн хөгжлийн хувьд бэрхшээлтэй болно гэдгийг тэмдэглэжээ.

Хятадын хэвлэлд улс орныхоо хүн ам, түүнийг судлах ухааны арга зүйн асуудалд задлан шинжилгээ хийсэн суурь судалгаа, онолын өгүүллүүд олноор нийтлэгдэж байна. Ийм ажлын нэг бол хятадын нэрт эрдэмтэн Тянь Сюеюаний бичсэн «Хүн ам зүйн шинэ онол» (Харбин, 1983) ном юм. Үүнд БНХАУ байгуулагдсанаас хойшхи хүн ам зүйн онолын хөгжлийн үндсэн чиглэл, түүхэн хувьслыг харуулжээ. (65—76 дахь тал). Төрөлтийг хязгаарлах бодлого явуулах зайлшгүй үндэслэлийг гарган, түүнийг хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийн тухайд 50-иад онд боловсруулсан Ма Иньчуны хүн ам зүйн шинэ онол өнөө үед ч утга учраа гээгээгүй, түүний дараах «их үсрэлтийн» үндэс болсон, хүн амыг өсгөх онолын шүүмжлэл ч хятадын хүн ам зүйд цоо шинэ үе эхэлсний гэрч баталгаа болсон гэж Тянь Сюеюань аргагүй зөв зүйтэй тэмдэглэсэн бөгөөд ХКН-ын Төв Хорооны Ш бүгд хурлаас (1978 оны) хойш хүн ам зүйн онолын хөгжилд энэ талаархи шинжилгээ судалгааны ажлын хүрээг тэлсэн бас нэгэн үе эхэлснийг заажээ. Тянь Сюеюань марксизмын сонгодогуудын арвин өвд тулгуурлаж «нөхөн үйлдвэрлэлийн 2 төрөл» (эд баялагийн үйлдвэрлэл, хүн амын нөхөн төрөлт)-ийн онолын талаар бичсэн нь хятадын хүн ам зүйн томоохон ололтын нэг гэж тооцогддог.

Сүүлийн арван жилд хятадын нийгмийн харьцаа, эдийн засгийн хөгжлийн ахиц, хүн ам зүйн эрчимтэй бодлогын нөлөөгөөр гэр бүлийн байдал тодорхой хэмжээгээр өөрчлөгдлөө. Эрдэмтэн Гу Зяньтан хятадын эрт эдүгээ үеийн гэрлэх журам тогтолцоо, айл өрхийн байдал, гэрлэх насны өөрчлөлт болон гэр бүлийн бусад шинж төрхийг гүн гүнзгий судлан шинжилснээр Хятад улсад айл өрхийн бүрэлдэхүүн хэмжээ багасан өөрчлөгдсөн байна гэж дүгнэн цэгнэжээ. (120— 151 дэх тал)

Хятадын хүн ам зүйчид, өнөөдөр, зуун жилийн дараах өөрийн орны хүн амын ойролцоо дөхүү тоог тогтоохыг ихэд анхаарч байна. Үүнд Сун Зянь, Тянь Сюеюань, Юй Зиньюань, Ли Гуаньюань зэрэг эрдэмтэд нэг эмэгтэйн дундаж төрөлтийг янз бүрийн үзүүлэлтэд тулгуурласан хүн амын таван хувилбар тооцоог цахим тооцоолуур хэрэглэн гаргажээ. Ингэхдээ тэд, засаг төрөөс хүн амын өсөлт хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулахад нь шинжлэх ухааны үндэстэй мэдээ хэрэглэгдэхүүнээр хангахын тулд зуун жилийн доторхи хүн амын хөгжлийн төлөв байдлыг тогтоохыг зорьсон байна. (156—197 дахь тал)

Том хотуудын өсөлт, шилжин суурьших явдлыг эрс хязгаарлан, хотжил төвлөрөлийг зохицуулах нь хотын хүн ам хэт олшрохоос хамгаалахад тус дөхөм болж байна. Сунь Панышоу «БНХАУ-ын хотын хүн амын тоо, өөрчлөлт» өгүүлэлдээ дээрх үйл хэргийн үндсэн арга байдлыг тусгажээ. (202—231 дэх тал)

Өнөөдөр Хятадын хүн ам зүйн ухаан нярай хүүхдийн үхэл эндэлийг багасгах талаар онцгой анхаарч байна. «Хятад дахь нярай хүүхдийн үхлийг тооцоолон дүгнэх дам тойруу арга» (284—297 дахь тал)

хэмээх өгүүлэлдээ Ло Маочу энэ тухай нарийн тодорхой авч үзжээ.

Америкийн мэргэжилтэн Джон Бонгаартс, Сьюзен Гринхалф нар Хятадын хүн амын бодлогын түүхэн хөгжил, түүнээс урган гарах болзошгүй хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн үр дагаврыг судалсны үндсэн дээр анхны хүүхдийг нэлээд хожуу төрүүлэх (анхны төрөлтийн нас 25-аас багагүй байхаар) хийгээд төрөлтийн хоорондын зайг уртасгах замаар өрх тутам хоёр хүүхэдтэй байж болох санал дэвшүүлсэн нь «өрх тутамд нижгээд хүүхдээр хязгаарлах бодлогыг өөрчлөх арга зам» болсон байна. Иймэрхүү санаа урьд өмнө ч хятадын хүн амын бодлогын арга зорилтыг тогтоон боловсруулах үед гарч байсан бөгөөд америкийн хүн ам зүйчид, хүн амын тоог төлөвлөн тооцоолоход ашигласнаар төрөлтийг эрс багасгахад нөлөөлөх төрөлтийн хугацааны өөр хувилбарыг санал болгосон нь чухал юм.

Хятадын нийгмийн шинэчлэлийн үрээр өрх тутамд хүсэх хүүхдийн тоо хэмжээ багасаж, төрөлтийг хатуу хязгаарлах шаарлагагүй болно гэж тэдний үзэж байгаа нь анхаарууштай боловч хятадын нийгэм улс төрийн байдлаас үндэслэсэн хүн ам зүйн хөгжлийн онцлогийг хүлээн зөвшөөрөхгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй гэж Зөвлөлтийн эрдэмтэд хэлжээ.

#### **Ч. БАТЦЭЦЭГ**

### **JAMSRANGYIN TSEVEEN'S CONCEPT OF SOCIALISM**

**L. Bat-Ochir D. Ulambayar**

Prof. J. Tseveen, a well-known Orientalist, who was educated in St. Peterburgh Russia, played an active part in setting up the Mongolian Revolutionary Party and carrying out the 1921 people's revolution. From the mid 1920's, there arose a heated debate among the Party leaders and in the Party itself on the nature of the future social development and the country's independence. J. Tseveen the Party Auditting Committee member, set forth suggestions on these issues.

He held the view that the road to socialism for nomads would take a specific form differing from the one sought by the founders of Marxism. He then elaborated a concept of a specific route to socialism in Mongolia and proposed a social development programme, which was related to the existing socio-economic conditions of the country and which could be called an Asian version of co-operative socialism with a theoretical and ideological foundation.